# ӨЛЗИЙТ СУМЫН ГХУССЗ-ИЙН 2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2019.07.03

ГХУССЗ-ийн дарга Х.Отгонмөнх

# Удирдлага, зохион байгуулалтын талаар





ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛААР 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ ХЭЛЭЛЦҮҮЛЖ БАТЛУУЛСАН.

# Сумын ГХУССЗөвлөлийн фэйсбүүк хуудас болон ИТХ-ын сайтанд тогтмол мэдээлэл байршуулж байна.











СУМЫН БҮХ МАЛЧИН ӨРХИЙН ТУСНЫ ЖАГСААЛТ, МАЛЧДЫН БҮЛГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, МАЛЫН ИМ ТАМГА, МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ БҮХИЙ "ӨЛЗИЙТ СУМЫН МАЛЫН ИМ ТАМГА-2" НЭРТЭЙ ГАРЫН АВЛАГЫГ БЭЛТГЭЖ ХЭВЛҮҮЛЭН 450 ӨРХӨД ТАРААВ.

МОНГОЛ ЦЭРГИЙН БАЯР АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН ЯВУУЛЖ, 5 ТӨРЛИЙН ТЭМЦЭЭН УРАЛДААН ЯВУУЛЖ, 3 ӨДӨР АРХИ СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОЖ, ЦЭРГИЙН БАЯРЫГ 3 ДАХЬ ЖИЛДЭЭ АРХИГҮЙ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭВ.



МОНГОЛ УЛСАД ОРЧИН ЦАГИЙН ЗЭВСЭГТ ХҮЧИН ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 98 ЖИЛИЙН ОЙ "МОНГОЛ ЦЭРГИЙН БАЯР-2019" ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Үйл ажиллагааны зорилго:
Сумын залуучууд,өсвөр үеийг эх оронч хүмүүжлээр хүмүүжүүлэх,
ахмад үеэсээ суралцах,үлгэр дууриал авахад оршино.
Зохион байгуулагдах хугацаа,газар: 2019.3.16-18-ны өдрүүдэд Өлзийт сумын төвд

2019.3.16 ны өдөр
09.00: Шагайн харваа /Багийн харваа, хувийн цуваа/
13.00: Д.Лхагва-Очирын нэрэмжит сугалаа
15.00: Үндэсний бөхийн барилдаан /Зөвхөн Өлзийт суманд ажиллаж амьдарч байгаа залуучуудын дунд/

2019.3.17-ны өдөр
09.00: Гар бөмбөгийн тэмцээн /18-с дээш насны эрчүүдийн дунд/
12.00: Дартсын тэмцээн /18-с дээш насны эрчүүдийн дунд/
13.00: Даалууны тэмцээн /40-с дээш насны эрчүүдийн дунд/

2019.3.18 ны өдөр
10.00: Төрийн дуулал, төрийн далбаа залах ёслол,Баярын хурлын нээлт
10.10: Хүндэт зочдыг хүндэтгэлийн суудалд урьж,танилцуулах
Зөвлөгөөн нээж Тэргүүлэгчдээс үг хэлэх
Сумын эрэгтэйчүүдийн зөвлөлийн 2018 оны товч тайлан
Сумын Засаг даргын мэндчилгээ
Хүндэт зочдын мэндчилгээ
10.30: Шагнал гардуулах,ёслолын ажиллага
11.00: Дотоод зохион байгуулалтын асуудал
18.00: Туяа оройн тоо
19.30: Хүндэтгэлийн концерт, удшийн цэнгүүн

Өлзийт сумын
Эрэгтэйчүүдийн зөвлөл



# ЦЭРГИЙН БАЯРЫН ТЭМЦЭЭНҮҮД





# ЦЭРГИЙН БАЯРЫН ТЭМЦЭЭНҮҮД





# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД БУСДЫН БИЕД ГЭМТЭЛ УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР ЯВАГДАЖ БУЙ “НЭГ ХОРОМ” АЯНД НЭГДЛЭЭ.



# 2019.05.01-НИЙ ӨДӨР ХҮРТЭЛ ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ЗАХИРАМЖ ГАРГУУЛАН ХЭРЭГЖИЛТЭНД ХЯНАЛТ ТАВИН АЖИЛЛАЖ БАЙНА



ДУНДГОВЬ АЙМАГ
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 28 өдөр Дугаар А/13 Рашаант

Хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.5, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 6 дугаар зүйлийн 6.2, 24 дүгээр зүйлийн 24.3, Хүүхдийн хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, Хөдөлмөрийн сайдын 2016 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн А/63 дугаар тушаалаар баталсан "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ын 3.10.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өлзийт сумын нутаг дэвсгэрт жил бүрийн 11 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, боосоот уралдаан, мялаалганы найрын уралдаан, уралдааны өмнөх үсэргээ, сунгаа зохион байгуулах, оролцохыг хориглосугай.

2. Өвөл, хаврын байгаль цаг аарын таагүй нөхцөлд морины уралдааны үед үүсч болзошгүй сөрөг нөлөө, үр дагаврыг олон нийт, ялангуяа уяачид, эцэг эхчүүдэд цаг алдалгүй сурталчилж, багийн хэмжээнд 11 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, боосоот уралдаан мялаалганы найрын уралдаан, уралдааны өмнөх үсэргээ, сунгаа зохион байгуулах, оролцохыг хориглосон мэдэгдэл гарган ажиллахыг сумын уяачдын холбооны тэргүүн (Б.Гасрандорж)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн мөрдөгч (Р.Мөнхбат), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангаж Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг дээрх албан тушаалтнуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.ЭРДЭНЭБАТ



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 01 өдөр Дугаар А/54 Мандалговь

Хурдан морины уралдаан
зохион байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 6 дугаар зүйлийн 6.2, 24 дүгээр зүйлийн 24.3, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн А/36 дугаар тушаалаар баталсан "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ын 3.10.2, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоол, Хүний эрхийн үндэсний комиссын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 1/10 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн нутаг дэвсгэрт жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, боосоот уралдаан, мялаалга найрын уралдаан, уралдааны өмнөх үсэргээ, сунгаа зохион байгуулах, оролцохыг хориглосугай.

Хоёр. Өвөл хаврын байгаль цаг агаарын таагүй нөхцөлд морины уралдааны үед үүсч болзошгүй сөрөг нөлөө, үр дагаврыг олон нийт, ялангуяа уяачид, эцэг эхчүүдэд цаг алдалгүй сурталчилж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх сумдын Засаг дарга, "Нарны хүлэг" морин спорт уяачдын холбоо (Ц.Ганхүү), сумдын Морин уяачдын холбооны тэргүүн нарт үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд онцгой хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Ц.Ганзориг), Цагдаагийн газар (О.Амарсанаа), Боловсрол, соёл урлагийн газар (Ц.Бумангэрэл), тайлан нэгтгэн тухай бүр танилцуулж байхыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

Дөрөв. Аймгийн Засаг даргын 2018 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн А/63 тоот "Хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглох тухай" захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

488010160

# ЕБС-ИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ЗҮГЭЭС ОХИДЫГ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨХӨӨС ХАМГААЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР ХӨДӨӨГИЙН БАГУУДЫН 50 ЭЭЖИД “ОХИНТОЙ ЭЭЖ” СЭДЭВТ ЗАХИДАЛ БИЧИЖ 2019 ОНЫ 4-Р САРД ХҮРГҮҮЛСЭН.



**ОХИНТОЙ ЭЭЖИД**

**Сайн байцгаана уу**

Сайхан зуншиж байна уу? Та бүхэнд миний захидал очих өдрийн мэнд хүргэе.

Захидал бичих болсон учир юу вэ? гэвэл

Өнөөгийн энэ нийгэмд бид дандаа л хар, муу мэдээ сонсох боллоо. Бэлгийн хүчирхийлэл, цахим гэмт хэрэг, үе тэнгийн дарамт гэх мэт сэтгэл зовоосон мэдээлэл олонтоо сонсогдож байна. *Тийм учраас аав, ээждээ аз жаргал бэлэглэж, гэрийнхээ хойморт ургаж байгаа цэцэг цэвэрүү шиг охин үрээ* нүдний хэээ цөцгий мэт хамгаалж байхыг энэ захидлаараа дамжуулан анхааруулж захих гэсэн юмаа. Танд дараах хэдэн зөвлөгөө өгье.

- Охин, хүүхэдтэйгээ илэн далангүй ярилцаж, тэдэнд юу тохиолдож байгааг нь асууж хамгийн дотны зөвлөгч нь байгаарай
- Охин үрээ гэртээ ГАНЦААРАНГ нь бүү үлдээ
- Охин үрээ хөдөө хээр ГАНЦААРАНГ нь малд бүү явуул
- Охин үрээ ус авахуулахаар худаг руу ГАНЦААРАНГ нь бүү явуул
- Охин үрээ үл таних эрэгтэй хүнтэй ГАНЦААРАНГ нь бүү үлдээ (олон хүн цуглах үед **жнь:** ноос ноолуурын үеэр, идэш авах үеэр, найр наадмын үеэр )
- Охин үрээ ГАНЦААРАНГ нь эрэгтэй хүнтэй хамт битгий явуул ( гэрээсээ хол явахад)
- Гэртээ согтуу хүн болон дэл сул эрэгтэй хүн ирж хоносон тохиолдолд ээж та охин үрээ өвөртөлж унтаарай

Ариун нандин, үзэсгэлэнтэй цэцэг мэт охин үрд хорон муу санаа хүрэх төдийд ялдам зөөлөн дэлбээ нь амьдралд хэзээ ч сэргэхгүйгээр тасарч болох юм шүү.

**Хүндэтгэн захидал бичсэн:**

Сургуулийн нийгмийн ажилтан, сумын хамтарсан багийн гишүүн Б.Жавзмаа

Нийгмийн ажилтан хүн хувийн нууцыг чандлан хадгалахаар хуулиар үүрэг хүлээсэн байдаг билээ. Иймд танд асууж лавлах, зөвлөгөө авах шаардлага гарвал 88876659 утсанд хандана уу



# ЕБС-ИЙН ДОТУУР БАЙР БОЛОН ХИЧЭЭЛИЙН БАЙРНЫ ДУНДУУРХ ЗАМД ХААЛТ ХИЙЖ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЯЗГААРЛАН ДОТУУР БАЙРЫН СУРАГЧДЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛЛАА.





# ОНХС-ИЙН 3.0 САЯ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ЕБС-ИЙН СПОРТ ЗААЛНЫ ОРЧНЫГ КАМЕРЖУУЛАН НИЙТ 8 КАМЕР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ СУУРИЛУУЛСАН.





# ОНХС-ийн 3.0 сая төгрөгийн санхүүжилтээр ЕБС-ийн спорт заалны орчныг камержуулан нийт 8 камер, тоног төхөөрөмжийг суурилуулсан.



# ОНХС-ИЙН 3.0 САЯ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ЕБС-ИЙН СПОРТ ЗААЛНЫ ОРЧНЫГ КАМЕРЖУУЛАН НИЙТ 8 КАМЕР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ СУУРИЛУУЛСАН.






# СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН Б.ЖАВЗМАА 2019.06.05-НД НИЙТ ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ХҮҮХДИЙНХЭЭ ЗУНЫ АМРАЛТЫН ХУГАЦААНД АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ НЬ ХАНГАХ, ЭРСДЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ ХИЙЖ ЗӨВЛӨМЖ ӨГСӨН.





# ЕБС АЖИЛЧДЫН ХҮЧЭЭР ГАДНА ХАШААНЫХАА ҮҮДЭНД 20-Н УНАДАГ ДУГУЙН ПАРК ЗОГСООЛ ХИЙЛГЭСЭН.





## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР 3 УДАА УУЛ УУРХАЙГААР 3 УДАА ХАМТАРСАН ШАЛГАЛТ ХИЙЖ ХУУЛЬ БУСААР ЖОНШ ОЛБОРЛОСОН 2 ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЭН, ЗӨРЧИЛ ҮЙЛДСЭН 11 ХҮНИЙГ НИЙТ 2.200.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОЖ СУМЫН ХҮҮ ТОРГУУЛИЙН ОРЛОГОД ТӨВЛӨРҮҮЛСЭН.





# ГЭМТ ХЭРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



# Зарцуулсан төсөв, хөрөнгө

| № | Хэрэгжүүлсэн үйл ажилагаа | Хэрэгжүүлсэн хугацаа | Мөнгөн дүн ₮ | Эх үүсвэр |
|---|---|---|---|---|
| 1 | "**Малын им, тамганы жагсаалт**" гарын авлага | 2019 он 03-р сард | 900.000 | Малчидаас |
| 2 | Монгол цэргийн баярт зориулсан үйл ажиллагаа | 2019 он 03-р сард | 2.250.000 | Нутгийн зөвлөл, ААНБ-ын хандив, тусламж |
| 3 | Эргүүл шалгалтын шатахуун | 2019 оны 1-р улиралд | 545.000 | Сумын ИТХ, ЗДТГ |
| 4 | Бичиг хэргийн зардалд | 1-р улиралд | 30.000 | ИТХ, ЗДТГ-аас |
| | Спорт заалны камержуулалт | 2-р улиралд | 3.000.000 | Сумын ОНХСан |
| **Нийт: 6.725.000 төгрөг** | | | | |